

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2024 оны 07 дугаар сарын 09-ний өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-2

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 3-11

1.Байнгын хорооны даргыг сонгох тухай 3-11

**Монгол Улсын Их Хурлын ес дэх удаагийн бүрэн эрхийн анхдугаар чуулганы
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны
2024 оны 07 дугаар сарын 09-ний өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн С.Замира ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 22 гишүүнээс 22 гишүүн хүрэлцэн ирж, 100 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 12 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Нэг.Байнгын хорооны даргыг сонгох тухай

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Л.Мөнхбаатар, Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл нар Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсенийг Байнгын хорооны даргад нэр дэвшүүлсэн талаар танилцуулав.

Мөн Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн гишүүн, Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг Байнгын хорооны даргад нэрээ дэвшүүлэв.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатарын тавьсан асуултад Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхбат үг хэлэв.

Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх асуудлаар Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг хуралдах шаардлагатай байгаа тул 20 минутын завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар завсарлага авав./11:27/

Хуралдаан 11 цаг 27 минутаас 11 цаг 37 минутад түр завсарлав.

Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс авсан завсарлага дууссаныг мэдэгдэв./11:38/

Нэр дэвшигчдээс Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга, З.Мэндсайхан, Р.Сэддорж нарын тавьсан асуултад нэр дэвшигч, Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен, П.Батчимэг нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир, Ц.Идэрбат, У.Отгонбаяр нар үг хэлэв.

Хуралдаан даргалагч, Улсын Их Хурлын гишүүн С.Замира санал хураалтын төхөөрөмж сааталтай байгаа тул санал хураалтыг илээр, гар өргөж явуулах горимын санал гаргав.

С.Замира: Улсын Их Хурлын гишүүн С.Замирагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 8
Бүгд: 22

63.6 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул санал хураалтыг гар өргөж явуулахаар тогтов.

С.Замира: Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсенийг сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 8
Бүгд: 22

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 10 минутад хэлэлцээж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 48 минут үргэлжилж, 22 гишүүнээс 22 гишүүн хүрэлцэн ирж, 100 хувийн ирцтэйгээр 12 цаг 10 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

С.ЗАМИРА

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 07 дугаар сарын 09-ний өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Үндсэн хууль” танхим
11 цаг 12 минут.

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

С.Замира: Өнөөдрийн хуралдаанд хүрэлцэн ирсэн гишүүдийн амар амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, ирц 100 хувьтай бүрдсэн тул Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2024 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Ирцийг танилцуулъя. Гишүүдийн ирцийг. Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанд гишүүн Очирбатын Амгаланбаатар, Тилеуханы Аубакир, Жигжидийн Батжаргал, Жадамбын Бат-Эрдэнэ, Пүрэвийн Батхишиг Батчимэг уучлаарай, Буланы Бейсен, Гомбын Ганбаатар, Сайнхүүгийн Ганбаатар, Мөнгөнцогийн Ганхүлэг, Сайнхүүгийн Идэрбат, Сүрэнжавын Лүндэг, Мэндбаярын Мандхай, Цагаанхүүгийн Мөнхбат, Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан, Загджавын Мэндсайхан, Нанзадын Наранбаатар, Ухнаагийн Отгонбаяр, Ренчинбямбын Сэддорж, Ганзоригийн Тэмүүлэн, Агваанлуvsангийн Ундраа, Болдын Уянга, мөн миний бие Сонгобайн Замира хүрэлцэн ирсэн байна.

Нэг.Байнгын хорооны даргыг сонгох тухай

Хэлэлцэх асуудалд оръё. Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал танилцуулъя. Нэгд Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх тухай. Хэлэлцэх асуудлын талаар саналтай гишүүн байна уу? Байхгүй. Хэлэлцэх

асуудлын талаар Байнгын хорооны, тийм, Байнгын хорооны даргад нэр дэвшигчийн талаар Улсын Их Хурал дахь Монгол ардын намын бүлгийн дарга Мөнхбаатар үг хэлнэ.

Л.Мөнхбаатар: Байнгын хорооны эрхэм гишүүдийн амрыг эрье. 2024 оны ээлжит сонгуулиар байгуулагдсан Улсын Их Хурал түүний бүтцийн байгууллагууд байгуулагдаж байна. Ингээд Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны даргад нэр дэвших асуудлыг өнөөдөр бас ийнхүү хэлэлцэж байна. Ингээд улс төрийн намууд, парламентад суудалтай зарим улс төрийн намууд хамтран ажиллах талаар бас тодорхой санамж бичиг байгуулсан. Түүнээс гадна Улсын Их Хурал дахь сонгогдсон гишүүдийн тоог бас харгалзан Байнгын хороодыг бас хувааж, хамтран ажиллах шаардлагатай гэж Улсын Их Хурлын удирдлага бас үзсэн байгаа.

Тийм учраас Ардчилсан намд 3 Байнгын хороог харьяалуулахаар шийдвэрлэсэн. Үүний нэг нь бол БОХХАА-н байнгын хороо байгаа юм. Тэгэхээр энэ БОХХАА-н байнгын хороон даргад Ардчилсан намаас нэр дэвшүүлнэ. Цогтгэрэл дарга нэр дэвшүүлнэ. Үүнийг бас дэмжиж өгөхийг эрхэм гишүүдээс хүсье.

С.Замира: Мөнхбаатар даргад баярлалаа. Байнгын хорооны даргад нэр дэвшигчийн танилцуулгыг Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл танилцуулна.

О.Цогтгэрэл: Байнгын хорооны хурлыг даргалагч эрхэм гишүүдийн амгаланг айлтгая. Бас Улсын Их Хурлын сонгуулийн ээлжит сонгуулийн дүнгээр Улсын Их Хурлын болоод бас Засгийн түвшинд бүхий л түвшинд бас тодорхой хэмжээнд харилцан ойлголцлын үйл ажиллагаа явагдаж байгаа.

Энэ хүрээнд Ардчилсан намаас БОХХАА-н байнгын хорооны даргад нэр

дэвшүүлэх бас ийм ойлголцолд хүрснийг сая бас Мөнхбаатар дарга танилцууллаа. Энэ хүрээнд Ардчилсан намаас нэр БОХХАА-н байнгын хорооны даргад нэр дэвшүүлж байгаа Улсын Их Хурлын гишүүн Буланы Бейсений товч танилцуулгыг та бүхэнд хүргэе.

Боловсрол эзэмшсэн байдлын хувьд Анагаах ухааны дээд сургуулийн хүний их эмч, мэс засалч, анагаах ухааны магистр, клиникийн профессор мэргэжилтэй. Ажилласан байдлын хувьд Баян-Өлгий аймгийн нэгдсэн эмнэлгийн эмч 88-аас 97 онд, 97-гоос 2007 онд Баян-Өлгий аймгийн нэгдсэн эмнэлгийн мэс заслын тасгийн эрхлэгч, 2007 онд Баян-Өлгий аймгийн эрүүл мэндийн газрын дарга, 7-гоос 12 онд Баян-Өлгий аймгийн мэс заслын тасгийн эрхлэгч, 12-оос 16 онд Баян-Өлгий аймгийн нэгдсэн эмнэлгийн дарга, 16 оноос Баян-Өлгий аймгийн нэгдсэн эмнэлгийн мэс заслын зөвлөх эмчээр, 2020-оос 24 онд Монгол Улсын Их Хурлын гишүүнээр, 24 оноос Монгол Улсын Их Хурлын гишүүнээр, 2020-оос 24 онд Их хурлын гишүүнээр ажиллаж байхдаа Хүнс, хөдөө аж ахуй, байгаль орчны байнгын хорооны гишүүнээр ажиллаж байсан. Бас орон нутгаас сонгогдсон. Өнгөрсөн 4 жил Байнгын хорооны гишүүнээр ажиллахдаа бас санаачлахдаа орон нутгийн асуудал, байгаль орчны, хүнс, хөдөө аж ахуйн асуудлаар бас идэвхтэй ажилласан.

Энэ талуудыг харгалзаад Ардчилсан намын зүгээс Буланы Бейсен гишүүнийг Байнгын хорооны даргад нэр дэвшүүлж байгаа юм. Та бүхнийг бас хэлэлцэн дэмжиж өгөхийг хүсье.

С.Замира: Цогтгэрэл даргад баярлалаа. Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх талаар өөр саналтай гишүүн байна уу? Саналаа хэлээрэй.

О.Цогтгэрэл: Та нэрийг нь дуудаж байж микрофон өгнө. Цагаанхүүгийн Мөнхбат гишүүн гэж та хэлэхээр

тэндээс, гишүүний микрофоныг өгье гэнэ.

С.Замира: Цагаанхүүгийн Мөнхбат гишүүний микрофоныг өгье. Батчимэг гишүүнээр тасалъя.

Ц.Мөнхбат: Хурал даргалагч, эрхэм гишүүдийн энэ өдрийн амрыг эрье. Манай говийн бүс нутаг болбол энэ байгаль орчин, хөдөө аж ахуйн чиглэлээр бол асуудлууд нь хамгийн их тулгамдсан ийм бүс нутаг. Ийм ч учраас говийн бүсээс сонгогдсон гишүүдийн дийлэнх нь энэ Байнгын хороонд орсон юм байгаа юм. Тэгээд манай нөхдүүд бол намайг бас энэ Байнгын хорооны даргад нэр дэвшүүлье гээд ингээд шийдсэн байсан. Тэгээд Бейсен ахтай бол нэг их ярих юм алга, ахмад хүн.

Тэгэхдээ мань манай бүлэг нэг 2, 3-хан хүн ярьж байгаад шийддэгээ л болих хэрэгтэй байна. Энэ Байнгын хороон дотор байгаа энэ Ардчилсан намынхаа гишүүдтэй бүх хоорондоо бүгдээрээ зөвлөлдөж байгаад яаж болдоггүй юм уу энэ чинь? Тэгээд говийн бүсийнхэн гэхээрээ юмны хойно суугаад байдаг, чимээгүй даруухан байгаад байдаг гээд ингээд байдаг юм уу? Энэ дээр бол гомдолтой байна. Тэгэхээр зэрэг хойшдоо энэ асуудал дээрээ жоохон хаана хаанаа ярилцаж, зөвшилцөж нэгэнт л ингэж л хийж байгаа болбол ингээд явахгүй болбол болохгүй байх шүү л гэж хэлмээр байна. Би одоо нэрээ дэвшүүлэхээ больё. Нэгэнт бүлэг ингээд яаж байгаа бол. Бейсен ахдаа амжилт хүсье. Ер нь бол би энийг бүлгийн даргад зориулж хэлж байгаа юм.

С.Замира: Батчимэг гишүүнд микрофон шилжүүлье.

П.Батчимэг: Шинээр сонгогдсон эрхэм Байнгын гишүүдийн хороод, Байнгын хороодын гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе. Манай Ардчилсан намын бүлгээс нэгдсэн шийдвэр гаргаж, гишүүдтэйгээ уулзаж, энэ асуудлаар

Байнгын хорооны даргын асуудлаар задгай орж ирж байгаа учраас би заалнаас нэрээ дэвшүүлэхийг хүсэж байна.

Энэ дээр нэмж хэлэхэд ер нь бол эмэгтэй шинээр сонгогдсон гишүүдийн хувьд, жагсаалтаар орж ирсэн гишүүдийн хувьд ер нь их тийм хаагдмал парламент руу орж ирлээ гэдэгтэй би бүр сэтгэл маш их тийм гонсгор байна. Засгийн газрын бүрэлдэхүүн дээр ч гэсэн ганц эмэгтэй сайд төлөөлж орох энэ асуудал яригдсангүй. Ерөнхий сайд хүртэл ярьж байсан. Эмэгтэйчүүд 30 хувь хүртэлх эмэгтэйчүүдийн энэ квотын асуудал энийг анхаарч үзнэ гэсэн. Тэгээд энэ асуудал ерөөсөө яригдсангүй явсаар байгаад бүдгэрээд өнөөдөр ийм байдалд орж ирлээ.

Мэдээж Байнгын хорооны энэ даргад нэрээ дэвшүүлэх энэ зоригийг бол би өөрөө гаргалаа. Бүлгийн дарга сууж байна. Сая бас Мөнхбат гишүүн хэллээ. Асуудлаа ярьж, гишүүдийнхээ дунд ингэж орж ирсэн бол ийм байдал үүсэхгүй байлаа. Ямар нэгэн байдлаар ард сууж хоцрохыг ерөөсөө хүсэхгүй байна. Тийм учраас парламентад гишүүд гишүүдийн, эмэгтэй гишүүдийнхээ төлөөлөл болж энэ Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны даргад заалнаас нэр дэвшүүлэхийг хүсэж байна. Намайг дэмжээрэй.

С.Замира: Цогтгэрэл гишүүн хариулт өгье.

О.Цогтгэрэл: Саяын бас асуултууд тодруулах шаардлагатай зүйлсүүд байх шиг байна. Яг яагаад Ардчилсан намаас бас бодлогоор Бейсен гишүүн орж ирсэн бэ гэдэг асуудлыг ярьж байна. Ардчилсан намын Үндэсний бодлогын хороо Улс төрийн зөвлөлийн хурал хуралдсан. Эндээс зөвшилцлийн ажлын, зөвшилцөл ойлголцлын ажлын хэсгийг намын даргад эрх шилжүүлсэн. Намын дарга энэ зөвшилцөл ойлголцлынхоо хүрээнд ажлуудыг ярилцаад бүлэгт өгсөн

ерөнхийдөө чиглэлийн хүрээнд хүрээнд 3 зүйлийг, 2 зүйлийг надад бас чиглэл болгосон.

1 дүгээрт нь энэ нам хоорондын ойлголцол энд ингээд явсан. 2 дугаарт нь Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэхэд бас туршилагыг харгалзаж, ажилласан туршилагыг харгалзаж үзэх ёстой буюу өнгөрсөн ингээд 2 дахиа сонгогдоод гараад ирсэн гишүүнийг нэр дэвшүүлэх нь зүйтэй гэдэг саналыг гаргасан. 2 дугаарт нь бас энэ тохиолдолд Ардчилсан намын хувьд бас нэг онцгойлж хэлэхэд Ардчилсан намын хувьд жагсаалтаар казах иргэдийн төлөөллийг нэр дэвшүүлсэн нь бас хараахан гишүүн болж чадаагүй. Олон, олон зүйлүүдийг харгалзаад энэ болбол бас үндэсний цөөнхийн хувьд бодлогоор нэр дэвшүүлэх ийм асуудал байгаа гэдгийг бас уламжилсан учраас Бейсен гишүүнийг дэвшүүлсэн шүү гэдгийг бас та бүхэнд дуулгая.

С.Замира: Амгаланбаатар гишүүнд микрофон шилжүүлбэ. Хэлэлцэх асуудлаа баталлаа. 2 нэр дэвшигчтэй учраас ингээд нэр дэвшигчээс асуух асуулт байна уу? Асуулттай гишүүд нэрээ өгнө үү. Амгаланбаатар гишүүний микрофоныг шилжүүлбэ.

О.Амгаланбаатар: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Хэдүүлээ бас энэ манай бүлгийнхэн бас нэг уулзсан нь дээр байх. Тэгээд 1 түр завсарлага аваад, хэдүүлээ бас нэг уулзалдахгүй болбол Мөнхбатын хэлж байгаа, энэ Батчимэгийн хэлж байгаа бас зөв шүү дээ. Тэгэхээр хэдүүлээ бас нэг уулзалдаад, эргэж орж ирээд хурлаа үргэлжлүүлсэн нь дээр байх гэсэн тийм санал гаргаж байна.

Энэ дээр зөвхөн намын шийдвэр гээд Цогтгэрэл юм ярьж байх шиг байна. Тэр намын шийдвэрээ ч гэсэн бид нар бас сонсьё л доо тийм ээ. Тэгэхгүй болбол хэдүүлээ ингээд л нэг ийм задгай яваад байх арай бас буруу байх шиг байна.

Тэгэхээр 10 минут завсарлага авдаг юм уу, яадаг юм.

С.Замира: Цогтгэрэл гишүүн хариулъя.

О.Цогтгэрэл: Бүлгийн гишүүдээс бас санал гарч байна. Тэгвэл бид нар бас Ардчилсан намын бүлгийн зүгээс 20 минутын завсарлага авъя. 20 минутын хүрээнд бид нар бас ойлголцлоо хийгээд ороод ирье.

С.Замира: Ардчилсан намын бүлэг 20 минутын завсарлага авлаа. Түр завсарлая.

Хуралдаан 11 цаг 27 минутаас 11 цаг 37 минутад түр завсарлав.

2 нэр дэвшигч ороод ирсэн байна. Тийм учраас бүлгийн даргаас асуух асуулт байвал асуугаарай. Бүлгийн даргад микрофон шилжүүлъя, уучлаарай.

О.Цогтгэрэл: Ардчилсан намын бүлгийн Хүнс, хөдөө аж ахуй, байгаль орчны байнгын хорооны гишүүд бас ярилцлаа. 2 гишүүн нэр дэвшсэн. Тийм болохоор хуралдаан даргалагчийг асуултаа үргэлжлүүлээд, бас санал хураалт хийж өгөхийг хүсье. Ардчилсан намын бүлгийн завсарлага дууссаныг бас мэдэгдье.

С.Замира: Аубакир гишүүнд микрофон шилжүүлъя. Асуух асуултаа асууна уу.

Т.Аубакир: Замира гишүүн жоохон чанга ярихгүй бол ерөөсөө сонсогдохгүй байна. Баярлалаа. Энэ Улсын Их Хурлын бас нэг бүрэлдэхүүн хэсэг л дээ Байнгын хороо гэдэг болбол. Дээрээс нь Хөдөө аж ахуй, байгаль орчны байнгын хороо бол шийдэх асуудлууд маш их байдаг. Тэгээд ингээд нэг нам нь оруулж ирээд, улс төрийн хувьд тохироо хийгээд ч явдаг ч ийм байгууллага биш. Хуулиараа болбол нээлттэй хэн ч нэр дэвших.

Энэ Байнгын хорооны дарга болсон хүний хувьд маш том маш их шийдэх ёстой чухал асуудлууд зөндөө байгаа. Энэ бэлчээрийн даац хэтэрсэнтэй холбоотой. Өнгөрсөн жил бид нар чинь гурилынхаа татварыг аваад хаячихсан. Энэ жилийн улаан буудай огцом буурсан. Энэ намар болбол улаан буудайн баланс барихгүй. Орос улсаас байнга ийм хямдхан гурил аваад л байх юм бодоод л татвараа чөлөөлчихсөн. Тэрийгээ бүсчилсэн байдлаар татвараас чөлөөлөх юм уу, яах юм гэх зэрэг энэ Их Хурал руу оруулах, шийдэх ёстой зөндөө ажлууд бий л дээ.

Тийм учраас одоо Байнгын хорооны дарга болж байгаа хүн болбол тэгээд л өнөөдрөөс эхлээд л ажилдаа орох ёстой. Энэ намрын ургац, наадмын маргааш намар гэж. Наадмын дараагаас эхлээд л ургац хадлангийн чинь асуудлууд эхлээд явчихна. Тийм учраас Ардчилсан намынхан Бейсен гишүүнийг нэр дэвшүүлж байгаа юм байна. Нутгийнхаа хүнийг дэмжилгүй яах вэ миний хувьд болбол. Тэгэхдээ ингээд юу гацаагаад яг зүгээр нэг албан тушаалд дуртай хүмүүс шиг энэ өрнөж байгаа байдал нэг ийм л ажиглагдаад байна яг ний нуугүй хэлэхэд. Бид нар дотроо байгаа боловч энэ чинь гаднаа энэ нийт сонгогчдын ярьж хэлж байгаа зүйл дээр энэ аль, аль бүлгийн удирдлагууд маань бас дорвитой шийдвэрүүд гаргамаар байна. Нэг л албан тушаал булаацалдсан, хуваарилсан байдалтай л гадна харагдаж байгаа юм.

Тэгээд л Ардчилсан намд ингээд л авах ёстой энэ Байнгын хороо гээд л. Энэ чинь бусад гишүүд нь яасан юм бэ? Энэ чинь туршилагатай гишүүд зөндөө л байна шүү дээ. Хөдөө аж ахуй яривал ярьдаг, хийвэл хийж байсан туршилагатай гишүүд зөндөө л байна. Тийм учраас дараагийн Байнгын хорооны дарга болох хүн дээр болбол нэлээн шаардлага тавьж ажиллана. Энэ Монгол Улсын Монголын хөдөө аж ахуйд шийдэх зөндөө ажлууд байж байгаа. Бүлгийн дарга нар маань жоохон

шийдвэртэй байж энэ ажлаа жоохон хурдан явуулсан нь дээр байх. Нутгийн гишүүний хувьд Бейсен гишүүнийг дэмжиж байна.

С.Замира: 2 гишүүд, нэр дэвшсэн 2 хүнээс асуух асуулт байна уу? Уянга гишүүнд микрофон шилжүүлбэ. Асуулт асуугаарай.

Б.Уянга: Энэ өдрийн мэнд хүргэе. 2 нэр дэвшигчээсээ асуулт асууя. Тэгээд аль илүү хариулж байгаад нь өөрийнхөө хувиас саналаа өгөөд явъя гэж бодож байна. Тэгэхээр Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлд бол яг байгаль, 23.3-д Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуй буюу манай Байнгын хорооны эрхлэх ажлын хүрээ бол ингээд маш олон агуулгатайгаар бичигдсэн байгааг та 2 маань хоёулаа мэдэж байгаа байх.

Тэгэхээр газар тариалан, хүнс, хөдөө аж ахуй, мал аж ахуй, малын даатгал бүүр геологи, уур уурхайн асуудал, агаарын бохирдолтойгоо хамт ингээд байгаа. Тэгэхдээ яг эд нар бол бүгдээрээ базагдаад хөдөөгийн хөгжлийн асуудал юм байгаа юм тийм ээ? Тэгэхээр та 2 маань яг хөдөөгийн хөгжлийг яг юу гэж харж байгаа вэ? 24-өөс 28 оны хооронд энэ Байнгын хороог ахаллаа гэж бодоход юун дээр илүү анхаарах вэ? Хөдөөгийн хөгжил гэж яг юу вэ?

С.Замира: 2 нэр дэвшигч ээлжлэн хариулт өгье. Эхлээд Бейсен гишүүнд микрофонд шилжүүлбэ.

Б.Бейсен: Эрхэм гишүүдэд энэ өдрийн амгаланг айлтгая. Миний хувьд ер нь аймгийн Иргэдийн хуралд 5 удаа дэвшээд гарсан. Тэгээд яг энэ хугацаанд бас хөдөө аж ахуйн аймгийн Иргэдийн хурлын, Хурал дахь хөдөө аж ахуйн хэлтэс дээр нь ажилласан. Нөгөө талаар энэ 20 онд Их Хуралд гарч ирчхээд энэ Байнгын хороон дээр ажилласан. Хэд хэдэн ажлын хэсэг дээр ажилласан. Жишээлбэл байгаль орчны чиглэлийн нөгөө талаар мах, энэ экспортын

чиглэлийн, тэгээд малын бэлчээрийн гэх мэтийн юун дээр ажилласан л даа.

Яах аргагүй хөдөө аж ахуйн чиглэл бол маш чухал алба энэ. Ялангуяа хүнсний асуудал байж байгаа. Сая газар тариалангийн асуудал байж байна, мал аж ахуйн асуудал байж байна, малын түүхий эдийн асуудал байж байна, агаарын бохирдлын асуудал байж байна. Энэ бүгд шийдэгдэхгүй байгаа асуудлууд зөндөө бий. Энийг шийдэхийн төлөө хамгийн гол нь энэ хавдар залуужиж байгаа энэ хүнсний аюулгүй байдалтай холбоотой асуудал байж байгаа. Ерөнхийлөгч дээр очоод би саналаа хэлсэн. Ерөнхийлөгчийн дэвшүүлж байгаа программ хүнсний аюулгүй байдлын программын асуудал байж байна. Энэ мэт шийдэх асуудлууд зөндөө байгаа хөдөө аж ахуйн чиглэлийн. Энэ дээр Хөдөө аж ахуйнхаа сайд дээр улс төржихгүйгээр хамтарч ажиллана.

Нөгөө талаар аймгийн Хөдөө аж ахуйн газрууд байж байна. Ялангуяа жижиг, дунд, хүнд үйлдвэрийн чиглэлээр газар тариалангийн асуудлууд байж байна саяын, бэлчээрийн асуудлууд байж байна энэ дээр хамтарч ажиллана. Тэгээд малын эрүүл мэндийн асуудал байж байна. Энэ дээр бас бид нар хамтарч ажиллаад, ажлын хэсэгт орж байсан. Энэ бүх шийдэх асуудлууд дээр хамтарч ажиллана гэж бодож байгаа.

С.Замира: Нэр дэвшигч Батчимэг гишүүнд микрофоноо шилжүүлбэ.

П.Батчимэг: Байнгын хорооны гишүүддээ өөрийгөө эхлээд нэг танилцуулахыг хүсэж байна. Яагаад гэвэл манай Бейсен гишүүнийг бол бүгдээрээ мэдэж байгаа байх. Их Хурлын гишүүнээр 4 жил ажиллалаа. Намайг Пүрэвийн Батчимэг гэдэг. Нийслэлийн иргэдийн Хурлын Төлөөлөгчөөр 2008, 2012, 2016 онд 3 удаа дараалан ажилласан. 2020 онд Улсын Их Хурлын сонгуульд Дорнод аймгаас нэр дэвшсэн. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн

салбарт 20 жил ажиллаж байна. Байгууллага удирдаж ажиллаж байгаа, бага зэргийн бас салбарын талаар ойлголттой. Улсын төсөв санхүүг арвижуулах, татвар бүх юманд нь оролцож энэ төсвийн ачааг бас үүрэлцэж 20 жил явж байна.

Хөдөө нутгийн хөгжил, хөдөөгийн тухай асуудал өнөөдөр тулгамдсан асуудал. Улс орны хөгжил гэдэг бол хөдөө нутгаас эхлэх ёстой. 2020 онд Дорнод аймагт нэр дэвшээд, улс төрийн миний үйл амьдрал Дорнод аймагтай холбогдож, 10 гаруй жилийг үзсэн байдаг. Энэ хугацаанд хөдөө орон нутгаар явж, малчидтай маш олон удаагийн уулзалтыг хийж явсан хүний хувьд хөдөө нутагт амьдрал ямар байгаа гэдгийг мал аж ахуйн талаас нь ч, газар тариалангийн талаас нь ч маш сайн ажиглаж мэддэг.

Өнөөдөр хөдөө нутагт ажлын байр хомсодсон, ажилгүйдэл улам ихэссэн. Үүнийг дагаад мал аж ахуйн, малаас гарах ашиг шим тэр ноос, ноолуур, мах, сүү, цагаан идээ энэ асуудлууд үнэгүйдсэнийг Монгол орон даяар бүгдээрээ мэдэж байгаа. Үүнийг дагаад боловсруулах үйлдвэрүүд байхгүй. Боловсруулах үйлдвэрээ дагаж байж ажлын байрууд нэмэгдэж, ингэж байж малчдын амьдрал өнөөдөр сайжрах ёстой. Малчид орлоготой болох ёстой. Заавал мал, мах, ноос ноолуураа бариад хаана байгаа хөдөө нутгаас зардал гаргаж, төвийг энэ Улаанбаатар хотыг зорих энэ бол маш их зардал гарч байгаа. Үнэгүйдсэн энэ ноолуур, энэ ноос, юу нэхий энэ асуудлыг арьс ширийг үнэтэй болгохын тулд жижиг, дунд үйлдвэрүүдийг олноор байгуулах ёстой юм байна лээ сумдад.

Газрын гарц муудсантай холбоотой байгаль экологийн өөрчлөлттэй холбоотойгоор малчдын амнаас ам дамжиж хамгийн их зовнисон асуудал нь малын бэлчээр хомс, бэлчээрийн хомсдол, дээр нь тэр эрдэс

бодис бүх юм нь байгалийн тэнцвэрт байдлаа алдагдаад мал маш их өвддөг болсон. Тийм учраас энэ бэлчээрийн хомсдол, энэ малаас гарах ашиг шимийг үнэтэй болгох энэ асуудлыг бид анхаарах ёстой юм байна лээ. Байгаль экологийн хувьд нь ч анхаарах ёстой юм байна лээ. Тийм учраас хөнгөн үйлдвэрлэл, хүнс, хөдөө аж ахуйн салбараар дагнаж ажиллаж байгаа хүний хувьд ер нь бол энэ асуудал дээр нэлээн нухацтай энд байгаа Байнгын хорооныхоо гишүүдтэй нэг бүрчлэн тулж, маш шаргуу ажиллах ийм зориг эрмэлзэл надад дүүрэн байна.

С.Замира: Мөнхсайхан гишүүнд микрофон шилжүүлбэ, Мэндсайхан.

3.Мэндсайхан: Ардчилсан нам маань тэгээд 2 хүн өрсөлдүүлчихье гэж байгаа юм байна. Тэгэхээр 2 дэвшигчээ тэгвэл хоёуланг нь л дэмжье дээ тийм ээ. Тэгэхдээ танайх хагалахгүй байгаа учраас бид нар дэмжээд шийдчих юм шиг байна. Бейсен гишүүнээ мэс засалч хүн, тэгээд та бас өөрөө бас энэ салбарыг Байнгын хороонд байх нэг асуудал л даа. Энэ салбарыг ер нь өрсөлдөх чадварыг нь юу гэж харж байна вэ?

Батчимэг гишүүн салбарын талаар хориод жил ажиллалаа. Энэ талаар бол бас тодорхой юм ярьж байна. Улс төржихгүйгээр хамтарч ажиллах асуудал огт биш л дээ. Тэр бол таны асуудал биш. Та энэ салбарт ер нь яг ямар бодлого барих гээд байгаа талаараа л хамтрах асуудлаа ярьж байгаа. Түүнээс биш таны Байнгын хорооны гишүүдтэй улс төржөөд, улс төржихгүй байна тэрийгээ илэрхийлээд байх бол нэг их тийм чухал асуудал биш байх. Зүгээр энэ салбарын хувьд ер нь яг хөдөө аж ахуйн өрсөлдөх салбарын өрсөлдөх чадварыг та юу гэж харж байна вэ? Хөдөөгийн хөгжил дээр юу гэж, ямар бодлого баримтлах гэж байна вэ гэдгийг л нэг сонсчихмоор байна.

С.Замира: Бейсен нэр дэвшигч хариулт өгье.

Б.Бейсен: Миний хувьд ер нь малчин гаралтай, малчин айлын хүүхэд л дээ. Тэр утгаараа энэ хөдөө аж ахуйн чиглэлийн хөдөөгийн амьдралыг бол маш сайн мэднэ. ...хөдөө байдаг. Өрсөлдөх чадварын хувьд энэ хөдөө аж ахуйн тулгамдсан асуудлууд байж байна. Газар тариалангийн асуудал байж байна, жимс ногооны асуудал байж байна, мал махны экспортын асуудал байж байна. Түүхий эдийн боловсруулах асуудлууд байж байна. Жишээлбэл малын түүхий эд, арьс шир, ноос ноолуур нөгөө талаар бэлчээрийн мал аж ахуй, эрчимжсэн мал аж ахуй, эрчимжүүлэх хөгжүүлэх асуудал дээр цаашидаа Засгийн газрын мөрийн хөтөлбөр бодлогыг нь баримтлаад яам салбарын яамтайгаа хамтарч ажиллана гэж бодож байгаа ерөөсөө.

С.Замира: Бейсен нэр дэвшигчид баярлалаа. Нэмж асуулт асуух гишүүд байна уу? Сэддорж гишүүнд микрофон шилжүүлье.

Р.Сэддорж: Баярлалаа, маш товчхон асууна. Тэгээд та 2 маань энэ говийн байгаль орчны цөлжилтийн эсрэг энийг шийдэхэд юу барьж ажиллах вэ? Ямар зүйлийг чухалчилж ажиллая гэж бодож байгаа вэ? Тэгээд байгаль орчны доройтол, энэ цөлжилттэй, тэгээд энэ говийн бүсийг л очиж харах хэрэгтэй дээ.

Тэгээд 2 дугаарт нь бол энэ уур уурхайгаас сүйдэж, бэлчээргүй болж байгаа, тоосжилтод өртөж байгаа, усгүй болж байгаа ард түмний амьдралыг хэрхэн харж байна вэ? Ийм л асуулт байна.

С.Замира: Бейсен гишүүнд микрофоноо шилжүүлье.

Б.Бейсен: Энэ говийн бүсэд би очоод бас үзэж байсан юм. Энэ уур уурхайтай холбоотой агаарын бохирдол, бэлчээрийн хомсдолын асуудлыг харсан. Ер нь зарим газарт нь бас мод тариалж

байгаа юм байна. Усны асуудлыг шийдэх асуудлууд байж байгаа. Энийг тухайн салбар яамны мэргэжилтнүүдтэй, эрдэм шинжилгээний байгууллагатай хамтарч шийдэхгүй бол зүгээр усны асуудал нь нэлээн хүнд юм байна. Засгийн газрын бодлого болгоод хэрэгжүүлээд, салбарын яамтай хамтарч шийдэхгүй бол энэ асуудал нэлээн хүнд асуудал. Агаарын бохирдлын асуудал үнэхээр хүнд юм байна лээ. Малыг тэр эрүүл мэндийн асуудал, бэлчээрийн хомсдолын асуудал, тэрийг бүгдийг нь харсан. Энийг шийдэх тал дээр бас ингээд хэрвээ энэ Байнгын хорооны даргаар сонгогдчихвол ЗГ-таа тавиад л, Байнгын хороодоор яриулаад л, салбарын эрдэм шинжилгээний байгууллагатай хамтарч байж шийдэхгүй бол, олон улсын байгууллагуудын төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх тал дээр анхаарч ажиллана.

С.Замира: Батчимэг гишүүнд микрофоныг өгье.

П.Батчимэг: Ер нь асуудал гэдэг болбол маш өргөн цар хүрээтэй, маш том хүрээнд бид нар ажиллах ийм маш том баг ажиллаж эхэлнэ. Тийм учраас би зүгээр бодохдоо говийн гэхээсээ илүү энэ явцуу нэг тийм юугаараа ажиллах тийм бодол алга байна. Ер нь нийт бидэнд энэ Байнгын хороонд ямар, ямар асуудлуудаар яаж бид нар нэг жилийн хугацаанд энэ эрчтэй хүчтэй хурдан ажиллах вэ гэдэг дээр тулгамдсан асуудлууд мэдээж ар араасаа орж ирэх байх. Тэр тухай бүрийн асуудлуудыг бид маш шуурхай, маш нягт авч ажиллах хэрэгтэй юм байгаа юм.

Зүгээр мэдээж говийн асуудал бол Монгол орны хувьд хамгийн эмзэг сэдэв болчихоод байгаа. Усгүй тэр говийг яах юм, ундгүй болсон тэр говийн ард түмнийг яах юм? Би өөрөө говь нутагт төрсөн эцэгтэй хүн. Тийм учраас Өмнөговийн тухай ойлголтыг хангалттай багаасаа нялхаасаа мэднэ. Ийм учраас энэ говь, цөлжсөн говийн

асуудал, усгүй говийн асуудал, нүнжиггүй, сэтгэлгүй газар ухагчдын хар гайгаар тэнд энэ байгалийн тэнцвэрт байдал алдагдаж, цөлжиж байгаа энэ Монголын говийг аврах ажлыг хамтдаа бүгдээрээ хийж чадна л гэж бодож байна. Хөтөлбөр, төсөл бид бүх юм руу орох ёстой юм байгаа юм. Бодлогын бүх юм руу орно гэж бодож байна.

Тийм учраас ер нь тулгамдсан энэ асуудлуудаасаа л ажлаа эхэлж явах байх даа манай энэ гишүүд бол. Тэгээд бүх асуудалд бол маш уян хатан, улс төржихгүйгээр, нухацтай, далайцтай, хүртээмжтэй ийм ажиллах чиглэлийг л тавьж ажиллах баг энд сууж байна гэж би харж байгаа.

С.Замира: Баярлалаа. Нэмж асуулт асуух гишүүд байна уу? Асуулт дууслаа, байхгүй гэж бодоод тасалъя. Үг хэлэх гишүүд байна уу? Идэрбат гишүүнд микрофоноо өгье.

Ц.Идэрбат: Тэгээд энэ удаа Улсын Их Хурлын бүтцийн маш том Байнгын хорооны даргын асуудал яригдаж байна. Тэгээд улс төрийн бас энэ хамтрах энэ баримтлал явж байгаа юм байна гэж ингэж ойлголоо. Тэгээд энэ Байнгын хороо ирэх 4 жил хийх ажил маш ихтэй. Энэ хүнсний хувьсгалын үр дүн гарч эхлэх ёстой. Энэ Цагаан алт хөтөлбөрийг хэрэгжүүлэх ёстой. Шинэ хоршоо хөтөлбөр гээд маш том хөтөлбөр эхлүүлчихсэн явж байгаа. Сая гишүүдийн хэлж байгаа энэ байгаль орчны сөрөг нөлөөллийн асуудлууд, говийн асуудал гээд.

Тэгээд энэ дээр Байнгын хороо маш тийм идэвхтэй санаачилгатай, зохион байгуулалттай, мөн яамандаа нэг их айхтар дөрлүүлээд байхгүй ийм Байнгын хороо байлгаарай л гэж би хэлэх гээд байгаа юм. Тэгэхдээ энэ Байнгын хорооны гишүүдийг даргаар сонгогдож байгаа хүмүүс маань өөрөө харж байгаа байх. Салбарын яамыг удирдаж байсан, энэ Байнгын хороог удирдаж байсан энэ

салбарын асуудлыг А, Б-гүй мэдэх олон хүмүүс энэ дотор байгаа. Шахаж шаардаж ажиллана гэдгээ би бүр эхний хуралдаан дээр нь хэлье гэж ингэж бас бодож байгаа юм.

Тийм учраас энэ Байнгын хорооны энэ томилгооны асуудал дээр ч гэсэн Ардчилсан нам зоонох тийм нөгөө хариуцлагатай хандаасай, энэ удаа бол бас хүндэтгэлтэй хандаж байна. Завсарлага аваад хоёроороо орж ирнэ гэдэг чинь, бүлгийн дарга нь суугаад нэг болгочхож чадахгүй байна гэдэг чинь бас зоонох хариуцлагагүй хандаж байна шүү л гэж би бас зориуд хэлье гэж ингэж бодож байгаа.

Энэ Байнгын хороо чинь айхтар тийм олон асуудал төвлөрсөн, энэ Байнгын хорооноос олон шийдвэрүүд гарахыг тэр хүлээсэн энэ хөдөө аж ахуйн салбарын асуудлууд энд яригдана шүү гэдгийг би нөгөө муу нуухаар сайн илчил гэж эхэндээ сайн, муугаа ярьчих нь зөв болов уу гэж бодож би зориуд бас хэлье гэж ингэж бодож хэлж байгаа юм. Баярлалаа.

С.Замира: Гишүүнд баярлалаа. Одоо Отгонбаяр гишүүнд микрофон өгье.

У.Отгонбаяр: Байнгын хорооныхоо гишүүдийн энэ өдрийн мэндийг эрэн мэндчилж байна. Тэгээд би бол Байнгын хороог бол Улсын Их Хурлын том уураг тархи гэж ойлгодог. Тэр дундаа БОХХАА-н байнгын хороо бол хамгийн чухал Байнгын хороо. Тийм учраас Ардчилсан намын бүлгээс Бейсен гишүүнийг нэр дэвшүүлж байгаад, мөн заалнаас Батчимэг гишүүн нэр дэвшиж байгаад бол хүндэтгэлтэй хандаж байна. Цаашидаа ард иргэд, тэр дундаа орон нутгаас бол нэлээн зүйлийг бас хүлээж байгаа гэдгийг цаг ямагт бас санах ёстой гэж би ойлгож байгаа.

Бид бүхэн цаашидаа шинэ тогтолцоо руу шилжиж байгаа. Тэр

дундаа бүсчилсэн хөгжлийн бодлого. Сая бас Идэрбат гишүүн хэллээ. Олон төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх ёстой. Тэр дундаа бүсчилсэн хөгжлийн бодлого гэдэг бол бид бүхний амин сүнс. Цаашдаа бүсчилсэн хөгжлийн бодлогоор дамжуулж хот, хөдөөгийн хөгжлийн ялгах ялгааг арилгах чиглэл рүү бол нэлээн дорвитой арга хэмжээ авч хэрэгжүүлэх ийм зайлигүй шаардлага байгаа. Энэ бүсчилсэн хөгжлийн бодлогыг хэрэгжихэд бол энэ БОХХАА-н байнгын хороо бол нэлээн жин дарж ажиллах ёстой ийм Байнгын хороо.

Тийм учраас 2 гишүүний 1 нь Байнгын хорооны даргаар томилогдох байх. Тэгээд томилогдох хүн бол энэ Байнгын хороог өдөр, шөнөгүй ер нь нэлээн ачаалалтай ажиллах ийм зайлигүй шаардлага байгаа шүү гэдгийг бас дуулгая. Тэгээд та бүгдэд нэр дэвшсэн хүмүүст амжилт хүсье.

С.Замира: Отгонбаяр гишүүндээ баярлалаа. Гишүүд үг хэлж дууслаа. Санал хураалтад оръё. Эхний ээлжид Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн, бүлгээс дэвшүүлсэн Буланы Бейсен нэр дэвшигчийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураая. Санал хураалт. Энэ үед алдаа гарсан учир энийг хүчингүйд тооцъё. Энэ тоног төхөөрөмж бас алдаа гаргаж байгаа учраас ил санал хураалт хураах уу? Гишүүд дэмжиж байна уу? Дэмжиж байгаа нь гараа өргөөрэй. Баярлалаа олонхын саналаар илээр санал хураая.

Эхний ээлжид Ардчилсан намын бүлгээс нэр дэвшүүлсэн Буланы Бейсен гишүүнийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалтад оролцсон гишүүд гараа өргөнө үү? Тоолчих.

Ингээд нэр дэвшигч 2 хүний эхний бүлгээс дэвшүүлсэн Бейсений Булан 22 гишүүний 14 нь дэмжиж, 63,6 хувийн дэмжлэг авсан учир Байнгын хорооны даргад Буланы Бейсенийг нэр дэвшүүлж, дэвшиж сонгогдсонд тооцъё. Чуулган

завсарлалаа. Ундраа гишүүн чуулганы нэгдсэн хуралдааны талаар танилцуулна уу. Аубакир гишүүн хуралдаанд танилцуулаад өгье, өгөөрэй. Нийтдээ 22 гишүүн оролцож, 14 гишүүнээр горимын санал дэмжигдлээ. 63.6 хувьтай.

12.10 цаг

Хуралдаан дууслаа, дууссанаа мэдэгдье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.УЯНГА